

**БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

*2024 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр, Пүрэв гараг*

*Хуралдааны тэмдэглэлийн агуулга*

*Хуралдааны товч тэмдэглэл:* 1-2

*Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:* 3-4

---

*1. Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж буй уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Засгийн газар 2024.04.10-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/* 3-4

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы  
Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны  
04 дүгээр сарын 18-ны өдөр /Пүрэв гараг/-ийн  
хуралдааны товч тэмдэглэл**

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга Ж.Батжаргал ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 19 цаг 09 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Т.Аубакир, Б.Бейсен, Г.Ганболд, Ц.Туваан;

Чөлөөтэй: Ц.Анандбазар, Х.Болорчулуун;

Эмнэлгийн чөлөөтэй: Д.Өнөрболор.

**Нэг.Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж буй уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Засгийн газар 2024.04.10-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн дэд сайд М.Ганхүлэг, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын референт Д.Батсүрэн, Сангийн яамны Төсвийн бодлогын газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Санхүүгийн хөрөнгө удирдлагын хэлтсийн дарга С.Тулга, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, мөн яамны Хуулийн хэлтсийн дарга Э.Цолмонжаргал, Жижиг, дунд үйлдвэрийн газрын дарга Я.Эрдэнэсайхан, Зээлийн батлан даалтын сангийн захирал С.Цогтсайхан нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтийн дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Мажигсүрэн, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Б.Баярсайхан нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Байнгын хорооны дарга Ж.Батжаргал Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-т заасны дагуу санал хураалгах горимын санал гаргав.

**Ж.Батжаргал:** Байнгын хорооны дарга Ж.Батжаргалын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 0

Бүгд: 10

Гуравны хоёроор дахин санал хураалгах санал дэмжигдлээ.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-т нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн боловч уг саналаар Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь дахин санал хураалгах шаардлагатай гэж үзсэний дагуу санал хураалт явуулав.*

**Ж.Батжаргал:** 1.Төслийн 6 дугаар зүйлийн 6.1.9 дэх заалтын “төсөв хооронд,” гэснийг, 6.2 дахь хэсгийн “Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон” гэснийг тус тус хасаж, төсөлд доор дурдсан агуулгатай 6.3 дахь хэсэг нэмж, үүнтэй холбогдуулан төслийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийн “6.2” гэсний дараа “, 6.3” гэж нэмэх:

“6.3.Энэ хуулийн 6.1.9-д заасан арга хэмжээг хэрэгжүүлэх зохицуулалт хийсэн тухай бүр Улсын Их Хуралд танилцуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 1

Бүгд: 11

100.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 19 цаг 17 минутад хэлэлцэж дуусав.*

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 08 минут үргэлжилж, 19 гишүүнээс 12 гишүүн хүрэлцэн ирж, 63.1 хувийн ирцтэйгээр 19 цаг 17 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**  
БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС,  
ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА

Ж.БАТЖАРГАЛ

**Тэмдэглэл хөтөлсөн:**  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ  
ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр,  
Пүрэв гараг  
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар”  
танхим  
19 цаг 09 минут.

### БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**Ж.Батжаргал:** Манай Байнгын хорооны гишүүд ирцдээ орчхоорой. Хэдүүлээ Уламжлалт мал аж ахуйнхаа уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй сөрөг нөлөөллийг бууруулах хуулийнхаа эцсийн хэлэлцүүлгийг хийе.

Байнгын хорооны гишүүдийнхээ оройн амар амгаланг айлтгая.

Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2024 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн хуралдаанд Тэмүүлэн, Бат-Эрдэнэ, Мөнхцэцэг, Наранбаатар, Саранчимэг, Дамдинням, Цэрэнпунцаг, Идэрбат, Энхтүвшин, Батжаргал нарын гишүүд хүрэлцэн ирснээр хуралдаан эхлэх ирц бүрдсэн байна. Ингээд хуралдаанаа нээлээ.

**Өнөөдрийн хуралдаанаар Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж буй уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хууль, тогтоолын төслүүдийн эцсийн хэлэлцүүлэг хийх.**

Хэлэлцэх нэг асуудал байна. Хэлэлцэх асуудалтай холбогдуулж саналтай гишүүд бий юү?

Алга байна. Хэлэлцэх асуудлаа баталлаа. Хэлэлцэх асуудалдаа оръё. Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулж ирсэн ажлын хэсгээ танилцуулъя.

Д.Амарбаясгалан Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, М.Ганхөлөг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн дэд сайд, Ч.Дондогмаа Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга, М.Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлогын газрын дарга, С.Тулга, Сангийн яамны Санхүүгийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, Ц.Болорчулуун Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Э.Цолмонжаргал Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хуулийн хэлтсийн дарга, Я.Эрдэнэсайхан Жижиг, дунд үйлдвэрийн газрын дарга, С.Цогтсайхан Зээлийн батлан даалтын сангийн захирал, Д.Батсүрэн Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын референт гэсэн ийм ажлын хэсэг байна.

Хэлэлцүүлэгт бэлтгэх ажлын хэсгийн танилцуулгыг хийе.

Байнгын хорооны гишүүдийнхээ оройн амар амгаланг айлтгая.

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 4 дүгээр сарын 10-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж буй уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг чуулганы нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлгийг 2024 оны 4 дүгээр сарын 18-ны өдөр явуулж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байнгын хороонд илжжүүлсэн.

Ажлын хэсэг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3 дахь заасны дагуу төсөлд шинээр 6.2 дахь хэсэг нэмэгдсэнтэй холбогдуулан төслийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт 6.3 дахь хэсэг нэмэх зарчмын зөрүүтэй нэг санал бэлтгэлээ.

Мөн нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулах үед

хуралдаан даргалагчаас хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Зээлийн батлан даалтын сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар гаргасан зарчмын зөрүүтэй саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгсөн.

Төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн мал бүхий иргэн, цаашид малчин гэх нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгийн явцад дэмжигдээгүй тул хамт өргөн мэдүүлсэн Зээлийн батлан даалтын сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 9.1.4 дэх заалтын малчин гэснийг малчин мал бүхий иргэн гэсэн зарчмын зөрүүтэй саналыг татан авч байгаа болно.

Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж буй уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанд бэлтгэх санал, дүгнэлт, энэ төсөл боловсруулах ажлын хэсгийн саналыг эцэслэн шийдвэрлэж өгөхийг та бүгдээсээ хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Ажлын хэсгийн танилцуулгатай холбогдуулж асуулттай гишүүд бий юү?

Асуулттай гишүүн байхгүй байна. Асуултыг тасаллаа.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3-т заасныг баримтлан ажлын хэсгээс нэг саналын томъёолол бэлтгэсэн. Энэ саналын томъёолол өөрөө бас Дэгийн хуулийн зохицуулалттай юм билээ. Гуравны хоёроор яах билүү тээ? Гуравны хоёроор явах ёстой. Энэ санал хураалгахыг дэмжье гэсэн саналтай байгаа гишүүд саналаа өгөх ийм томъёоллоор санал хураалт явуулъя. Гуравны хоёроор шүү. Санал хураалт.

Хуралдаанд оролцож байгаа гишүүд 100 хувийн саналаар санал хураалгахыг дэмжсэн тул хураалгах саналаа хэлье.

1.Төслийн 6 дугаар зүйлийн 6.1.9 дэх заалтын “төсөв хооронд,” гэснийг, 6.2 дахь хэсгийн “Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон” гэснийг тус тус хасаж, төсөлд доор дурдсан агуулгатай 6.3 дахь хэсэг нэмж, үүнтэй холбогдуулан төслийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийн “6.2” гэсний дараа “, 6.3” гэж нэмэх:

6.3 нь биш шүү дээ. Энэ биш шүү дээ.

“6.3.Энэ хуулийн 6.1.9-д заасан арга хэмжээг хэрэгжүүлэх зохицуулалт хийсэн тухай бүр Улсын Их Хуралд танилцуулна.” гэсэн ийм заалт байгаа юм. Нэмсэн юм. Үүнийг санал хураалт дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт хийе.

Санал хураалт хуралдаанд оролцсон гишүүдийн 90.9 хувиар санал дэмжигдлээ.

Уг асуудлыг хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Дамдинням гишүүн танилцуулна.

Байнгын хорооны хуралдааны хэлэлцэх асуудал дууссан тул өнөөдрийн хуралдааныг өндөрлүүлж байна. Идэрбат гишүүнээр тогтё.

Байнгын хорооны хуралдаанд оролцсон Байнгын хорооныхоо гишүүд, ажлын хэсгийнхэндээ баярлалаа.

19.17 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ  
БУУЛГАЖ ХЯНАСАН:  
ШИНЖЭЭЧ Д.ОТГОНДЭЛГЭР

